



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 4219

Улаанбаатар хот

“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд”
арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлэх талаар баримтлах бодлогыг нэгдүгээр, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг 2025-2028 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газар, Эмнэлгийн тусламжийн бодлогын газар (Р.Гантуяа), Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (Ж.Отгонбаатар), Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Л.Баттөр)-д тус тус даалгасугай.

3. Арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгахыг Санхүү, эдийн засгийн бодлогын газар (Э.Мөнхсүх), Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (С.Энхболд), Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулах газар (Н.Эрдэнэбаяр), хүний нөөцийг сургаж чадавхжуулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (М.Одгэрэл)-д тус тус үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

141251033



ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

ҮНДЭСЛЭЛ

Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилгод эх, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах, эндэгдлийг бууруулах асуудлыг онцгойлон тусгаж, 2030 он гэхэд дэлхий дахинд эхийн эндэгдлийг 100,000 амьд төрөлтөд 70-аас доош, тав хүртэлх насны хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг арилгах зорилт тавьсан. Өндөр орлоготой орнуудад эмэгтэй хүн насан туршдаа эхийн эндэгдэлд өртөх эрсдэл 1/5400 байдаг бол орлого багатай орнуудад 1/45 байна.

Эмэгтэйчүүд, хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэндийн дэлхийн стратеги (2016-2030 он)-т 2030 он гэхэд эмэгтэйчүүд, хүүхэд, өсвөр үеийнхэн бие махбодын болон сэтгэцийн хувьд эрүүл байх эрхээ эдлэх, нийгэм-эдийн засгийн боломжуудаа ашиглах, чинээлэг, тогтвортой нийгэм цогцлооход оролцох бүрэн боломжтой дэлхий ертөнцийг бий болгохыг зорьж байна.

Дэлхий дахинд эхийн эндэгдлийг бууруулахад томоохон ахиц гарч, 2000–2023 онд эхийн эндэгдэл 40 хувиар буурсан бөгөөд дэлхийн 3 улс тутмын 1 нь эхийн эндэгдэл багатай орны тоонд багтаж байна.

Сүүлийн 10 жилд хүүхдийн өсөлтийн хоцролтын тархалт тогтвортой буурч, 2022 оны байдлаар дэлхийд 5 хүртэлх насны хүүхдийн 22.3 хувь буюу 148.1 сая хүүхэд өсөлтийн хоцрогдолтой гэж бүртгэгдсэн бөгөөд тэдний талаас илүү (52%) хувь нь Ази тивд амьдарч байна. Мөн 5 хүртэлх насны хүүхдийн 6.8 хувь буюу 45 сая хүүхэд хоол тэжээлийн цочмог дуталтай, тэдний 13.7 сая нь хүнд хэлбэрийн дуталтай, 37 сая хүүхэд илүүдэл жинтэй байгааг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сан, Дэлхийн банкны хамтарсан үнэлгээний тайланд тэмдэглэсэн байна.

Хоол тэжээлээс шалтгаалсан эмгэг өсвөр насны охид, эмэгтэйчүүдийн амьдралд ихээхэн сөрөг үр дагавар учруулж байна. Дэлхийн 1 тэрбум гаруй өсвөр насны охид, эмэгтэйчүүд хоол тэжээлээс хамааралт эмгэгийн аль нэг хэлбэр, 3 өсвөр насны охид, эмэгтэйчүүд тутмын 2 (69%) нь төмөр, цайр, аминдэм, эрдсийн дуталд өртсөн байна. Өнөөгийн байдлаар дэлхийн аль ч бүс нутагт өсвөр насны охид, эмэгтэйчүүдийн дундах цус багадалтын тархалтыг 2030 он гэхэд 50 хувиар бууруулах олон улсын зорилтыг хангах боломж харагдахгүй байна. Сүүлийн 20 гаруй жилд буюу 2000 оноос хойш цус багадалтын тархалт огт буураагүй өсвөр үе, төрөх насны эмэгтэйчүүдийн 30 хувь нь цус багадалттай байна.

Эрүүл мэндийн тухай хуульд "... зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих; жирэмслэлт, төрөлт, төрсний дараах үетэй холбоотой эх барихын тусламж, үйлчилгээний зардлыг төр хариуцах"-аар зохицуулагдсан бөгөөд Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай, Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулиудад эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх заалтууд тусгагдсан.

Монгол Улсын "Алсын хараа-2050" урт хугацааны бодлогын баримт, бичгийн эрүүл мэндийн зорилтод "...иргэн, гэр бүл, ажил олгогчийн оролцоонд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, хүний нөөцийн хангалт ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулах, нотолгоонд тулгуурласан орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийг нэвтрүүлэх, чанар, гүйцэтгэлд тулгуурласан даатгалын тогтолцоотой болох, сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаснаар 2030 он гэхэд төрөлтийн нийлбэр коэффициентийг 3.3 хүртэл өсгөж, эхийн эндэгдлийг 100,000 амьд төрөлтөд 15, нялхсын эндэгдлийг 1000 амьд төрөлтөд 8 хүртэл бууруулна" гэж тусгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Эрүүл Монгол хүн" зорилт дэвшүүлж, гэр бүлийг хөгжүүлэх, эмэгтэйчүүд, хүүхэд, эрэгтэйчүүд, өсвөр үеийнхэн, ахмад настай, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хиймэл оюун ухааныг ашиглах, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, эмнэлгийн яаралтай тусламжийн тогтолцоог бэхжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлж зарцуулалтыг оновчтой болгох, өсвөр үеийнхэнд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, хүн төвтэй үйлчилгээ үзүүлэх, үйлчлүүлэгчийн эрхийг дээдлэх, хүүхдийг аливаа эрсдэлээс хамгаалах ..." талаар үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.1. "Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого" зорилгын хүрээнд "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхээр тусгасан.

Эрүүл мэндийн статистик үзүүлэлтээс харахад сүүлийн жилүүдэд төрөлтийн тоо буурч (2024 оны жилийн эцсийн байдлаар 57319 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 6596 төрөлтөөр буюу 10.3 хувиар буурсан), эхийн эндэгдэл (2024 онд 100,000 амьд төрөлтөд 22.5) болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (2024 онд 1000 амьд төрөлтөд 15.2) тогтвортой буурахгүй байна. 2024 оны байдлаар нийт төрөлтийн 17.8 хувь нь хүндрэлтэй, 28.2 хувь нь кесар мэс заслаар төрсөн байна. "Эх яагаад эндэв" 2000-2023 оны судалгаанаас харахад эндсэн эхийн 40.5 хувь нь аврах, 95.4 хувь нь

урьдчилан сэргийлэх боломжтой байсан ба жирэмсний хяналтын чанар сул байна гэж дүгнэжээ.

“Хүүхэд яагаад эндэв” 2000-2021 оны судалгаагаар нярайн эндэгдлийн 65.2 хувь нь эрт үеийн эндэгдэл, 34.8 хувийг хожуу үеийн эндэгдэл эзэлж байна. Тав хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 24.9 хувь нь эмнэлгээс гадуур, 75.1 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс хоног болоогүй нас баралт 23.8 хувийг эзэлж байна. Хүүхдийн нийт эндэгдлийн 85.1 хувь нь өвчнөөр, 14.9 хувь нь осол, гэмтлийн улмаас эндсэн байна. Перинатал үед үүссэн эмгэг 45.4 хувь, төрөлхийн хөгжлийн гажиг 15.1 хувь, амьсгалын тогтолцооны эмгэг 9.1 хувийг эзэлж байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл хөдөө орон нутагт (14.7) улсын дундаж (13.9)-аас өндөр байна.

Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн байдал 2024 оны Үндэсний VI судалгаанаас хүүхэд, эмэгтэйчүүдийн дунд хоол тэжээлийн цочмог дутал, тураалын тархалт бага байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд тав хүртэлх насны хүүхдийн дунд илүүдэл жин, таргалалтын тархалт нэмэгдэж байна. Төрөх насны эмэгтэйчүүдийн 53.0 хувь нь илүүдэл жин ба таргалалттай, 18.0 хувь нь тарган, 6–18 насны хүүхдийн 19.6 хувь нь илүүдэл жинтэй, 6.2 хувь нь тарган байна. Тав хүртэлх насны хүүхдийн 8.8 хувь нь өсөлтийн хоцролттой, 1.9 хувь нь тураалтай, 12.8 хувь нь илүүдэл жинтэй, 2.7 хувь нь хоол тэжээлийн цочмог дуталтай буюу туранхай байна. Тав хүртэлх насны хүүхдийн 21.3 хувь нь цус багадалттай, 48.5 хувь нь Д аминдэм, 6–23 сартай хүүхдийн 30.9 хувь нь төмөр дуталтай, 6–18 насны хүүхдийн 67.3 хувь нь тус тус Д аминдэм дуталтай, охидын 10.1 хувь нь цус багадалттай байна.

Бага насны хүүхдийн 71.9 хувь нь төрсний дараах 1 цагийн дотор ангир уургаа амласан, 51.1 хувь нь эхийн сүүгээр дагнан хооллосон, эхийн сүүгээр хооллосон 6–23 сартай хүүхдийн дөнгөж 28.8 хувь нь зохистой байдлаар хооллодог, 45.2 хувь нь нэмэгдэл хоолыг зохих нэр төрлийн хүнсээр баяжуулан хэрэглэж байна. Жирэмсэн (15.3%) болон нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн (14.3%) хоногт хэрэглэвэл зохих 5 нэр төрлийн хүнсний хэрэглээ маш бага, тэдний дөнгөж 11.4 хувь нь олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлээр хангагдсан байгаа нь бичил тэжээлийн дутал, ялангуяа төмөр, Д аминдэм дутал, цус багадалтад өртөх суурь шалтгаан болж байна.

Жирэмсэн эмэгтэйчүүдийн 22.3 хувь нь цус багадалттай, 13.6 хувь нь төмөр дутлын цус багадалтай, 39.6 хувь нь төмөр дуталтай байна. Судалгаагаар эмэгтэйчүүдийн жирэмсний хяналтад хамрагдалт 98.4 хувь байгаа хэдий ч тэд хяналтын явцад бичил тэжээлийн дутлаас сэргийлж чадахгүй, олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл хэрэглэх талаар дөнгөж 28.9 хувь нь зөвлөгөө авсан байлаа. Жирэмсний эхний 3 сартай эмэгтэйчүүдийн 7.5 хувь нь цус багадалттай байгаа бол 2 дахь гурван сартайд 21.5 хувь, 3 дахь гурван сартайд 28.4 хувь болж нэмэгдсэн. Төмөр дутлын тархалт жирэмсний 3 сар тутамд 2.8-3.0 дахин нэмэгджээ. Жирэмсэн эмэгтэйчүүдийн шээсээр ялгарах иодын голч хэмжээ 76.4 мкг/л байгаа нь ДЭМБ-аас зөвлөсөн лавлагаа хязгаар (150 мкг/л)-аас хэт доогуур, иод дуталд өртөх өндөр

эрсдэлтэй, төрөлхийн иодын дуталтай хүүхэд төрүүлэх магадлалтайг харуулж байна.

2023 онд хийгдсэн “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-аас гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай 15—49 насны эмэгтэйчүүдийн 49.8 хувь нь жирэмслэхээс хамгаалах арга, хэрэгсэл хэрэглэдэг бөгөөд тэдний 64.8 хувь нь жирэмслэхээс хамгаалах орчин үеийн арга, хэрэгслээр хангагджээ. Нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйд ногдох үр хөндөлтийн тоо дунджаар 7.3, нэг эмэгтэй ногдох үр хөндөлтийн нийлбэр коэффициент 0.3 байна.

“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлсэн бөгөөд үйл ажиллагааны хэрэгжилт 69.0 хувь, шалгуур үзүүлэлт 46.9 хувийн биелэлттэй байна гэж дүгнэгджээ.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

1. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд мөрдөж буй стандарт, журам, зааврын хэрэгжилт хангалтгүй, батлагдсан журам, зааврууд хоорондоо зөрөөтэй байна. Эмч, эмнэлгийн мэргэжилтний хууль, эрх зүйн мэдлэг сул байна.

2. Эх, нярай, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл тогтвортой буурахгүй, сэргийлж болох уушгины хатгалгаа, осол гэмтэл зэрэг өвчин эмгэгээр хүүхэд эндсээр байгаа бөгөөд эх, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламжийн чанарыг сайжруулахад онцгой анхаарах шаардлагатай байна.

3. Хүн ам, ялангуяа нөхөн үржихүйн насны эмэгтэй, өсвөр насныхан, хүүхдийн өсөлт, төрөлтийн тоо, хүн амын шилжилт хөдөлгөөн, өвчин, эмгэгийн хөдлөл зүйтэй уялдуулж хүний нөөцийг сургаж бэлтгэхгүй байна. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн мэдлэг ур чадварыг тогтмол дээшлүүлэх, тэдний эрхийг хамгаалах, эрх, үүргийг таниулах, цалин урамшууллыг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг хангах чиглэлд онцгой анхаарах шаардлагатай байна.

4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шинэ арга, аргачлалыг нэвтрүүлж, нутагшуулахад хүний нөөцийг сургаж бэлтгэдэггүй, стандарт, журам, зааврыг боловсруулж батлуулахгүй, санхүүжилтийг шийдвэрлэдэггүй зэрэг асуудлууд байсаар байна.

5. Эх, хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээлийн тусламж, үйлчилгээнд үр дүнтэй, өртөг багатай, нотолгоонд суурилсан үйл ажиллагааг нэвтрүүлж, нутагшуулах ажлыг эрчимжүүлэх, эмэгтэйчүүд, хүүхдийн хоол, тэжээлийн тусламж, үйлчилгээг жирэмсэн, төрөлт, төрсний дараах үеийн тусламж, үйлчилгээтэй нягт уялдуулах бодлого, эрхзүйн зохицуулалтыг бий болгох, бичил тэжээлийн дутлаас сэргийлэхэд чиглэсэн тушаал, журам, зааврыг шинэчлэн боловсруулах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээг тогтмол зохион байгуулах шаардлагатай байна.

6. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг төрөөс хариуцахаар хуульчилсан боловч санхүүжилт нь бодит өртөг зардалтай дүйцэхгүй байсаар байна.

7. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газраас эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж байгаа ч нийлүүлсэн тоног төхөөрөмжийн чанар муу, засвар үйлчилгээний санхүүжилт шийдвэрлэгдэхгүй, гамшиг онцгой байдал, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бэлэн байдал, нөөц бүрдүүлэлт хангалтгүй байсаар байна.

8. Судалгаа, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид тулгуурласан төлөвлөлтийг хийхгүй, судлаачдыг бэлтгэж чадавхжуулах ажил хангалтгүй байна.

9. Жирэмсэн эмэгтэйчүүдийн 11.5 хувь нь эмнэлгийн бус нөхцөлд эндсэн, 62.9 хувь нь биеийн байдал хүнд, маш хүнд үедээ эмнэлэгт хандсан байгаа нь эмэгтэй, түүний гэр бүлийнхний эсэн мэнд амаржихуй, аюулгүй жирэмслэлт, төрөлтийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх нэн чухал байна. Алслагдсан бүс нутаг, нийгмийн байдал, амьдралын нөхцөл зэрэг нь эхийн ноцтой хүндрэл, нас баралтад нөлөөлсөөр байна.

10. Эх, хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэндийн чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгааг зорилтот бүлгийн хэрэгцээнд тулгуурлан, тэдний сонирхолд нийцсэн хэлбэрээр зохион байгуулж, мэдээллийг нийтийн зах зээлд гаргахад анхаарах шаардлагатай байна.

11. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд бусад салбарын оролцоо болон салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа сул байна.

АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖ, ЭРСДЭЛ

БОЛОМЖ	ЭРСДЭЛ
➤ Эрүүл мэндийн багц хуулиудад эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх заалт үндэслэл тусгагдсан; ➤ Засгийн газрын бодит материаллаг (барилга, тоног төхөөрөмж) хөрөнгө оруулалт нэмэгдсэн; ➤ Олон улсын байгууллагын техникийн болон санхүүгийн дэмжлэг сайн; ➤ Мэргэжлийн нийгэмлэг, холбоодын оролцоо нэмэгдсэн; ➤ Бүс нутгийн онцлог, нөхцөлийг харгалзан төлөвлөлт хийхэд бусад салбарын дэмжлэг, эрхзүйн таатай орчин бүрдэж эхэлсэн.	➤ Бодлогын шийдвэрүүд өөрчлөгдөх; ➤ Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх сургагдсан хүний нөөц хангалттай биш; ➤ Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай санхүүжилт хүрэлцэхгүй байх; ➤ Олон улсын байгууллагын санхүүжилт буурах; ➤ Нийтийг хамарсан халдварт өвчин, гамшиг, онцгой байдлын бэлэн байдал, нөөц хангагдаагүй.

ЗОРИЛГО

Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих бодлого эрхзүй, нийгэм-эдийн засгийн таатай орчинг бэхжүүлж, эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх, эх, хүүхдэд зонхилон тохиолдох сэргийлж болох өвчин эмгэг, түүний хүндрэлийг багасгах замаар эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг тогтвортой бууруулах.

Хүрэх үр дүн

1. Эхийн эндэгдлийн харьцааг 100,000 амьд төрөлтөд 19.9 хүртэл бууруулна.
2. Нярайн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 7.1 хүртэл бууруулна.
3. Нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 8.7 хүртэл бууруулна.
4. Тав хүртэл насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 14.7 хүртэл бууруулна.

ЗОРИЛТ

Зорилт 1. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих бодлого эрхзүй, нийгэм, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэн, бусад салбар, төрийн бус байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоо, орон нутгийн шийдвэр гаргагчдын оролцоо, хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжин, уялдаа холбоог сайжруулах.

Хүрэх үр дүн 1.

1.1. Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад мөрдөгдөж буй бүтэц, үйл ажиллагааны стандартыг нягтлан, эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээрх үйл ажиллагааг тодорхой тусгаж үндэсний хэмжээнд мөрдсөн байна.

1.2. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлдэг санхүүжилтийн арга аргачлал, үйлчилгээний жагсаалтыг өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, шинэчлэн боловсруулж, үндэсний хэмжээнд мөрдсөн байна.

1.3. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн эрхийг хангах, нийгмийн хамгааллыг сайжруулах, цалин урамшууллыг нэмэгдүүлэх чиглэлээр бодлогын баримт бичиг батлуулан, хэрэгжүүлсэн байна.

1.4. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн албан тушаалын тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг шинэчлэн боловсруулж, батлуулан, үндэсний хэмжээнд мөрдүүлсэн байна.

1.5. Гамшиг, онцгой байдал, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн 6 сарын нөөцийг Ховд, Өвөрхангай, Дорнод, Өмнөговь аймгийн бүсүүдийн агуулахад бүрдүүлсэн байна.

Зорилт 2. Эх, ураг, нярайн эрт үеийн тусламж, үйлчилгээнд нотолгоонд тулгуурласан үр дүнтэй үйл ажиллагааг эрчимжүүлэх, дэлхийн хөгжингүй улс орнуудад нэвтрүүлж буй шинэ арга технологийг нутагшуулах, тусламж, үйлчилгээний байнгын бэлэн байдлыг хангах, төвлөрлийг сааруулж, хүртээмжийг нэмэгдүүлэн, чанарыг сайжруулж, эх, ураг, нярайн өвчлөл, эндэгдлийг бууруулах.

Хүрэх үр дүн 2.

2.1. Эх, нярайн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд олон улсын байгууллагын зөвлөмж болгож буй нотолгоонд тулгуурласан интервенцийг хэрэгжүүлэх, сургалтад үйлчилгээ үзүүлэгчдийн 80-аас доошгүй хувийг хамруулсан байна.

2.2. Эх, ураг, нярайн эрүүл мэндэд нэн шаардлагатай олон найрлагат бичил тэжээлийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлдэг болсон байна.

2.3. Эх, ураг, нярайн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн хангалтыг 80-аас доошгүй хувьд хүргэсэн байх бөгөөд засвар үйлчилгээний санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгаж хэвшсэн байна.

2.4. Жирэмсний эрт үеийн хяналт 2028 он гэхэд 96 хувь, жирэмсний хяналтад 8 болон түүнээс дээш удаа тогтмол хамрагдалт 82,5 хувьд хүрсэн байна.

2.5. Жирэмсэн эмэгтэйн цус багадалт 20 хувь хүртэл буурсан байна.

2.6. Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг бүрэн хэрэгжүүлсэн байгууллагын тоо 68-д хүрсэн байна.

2.7. Жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгслийн хангагдаагүй хэрэгцээг 30 хувь хүртэл бууруулсан байна.

2.8. Эрүүл мэндийн байгууллагууд жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн орчин үеийн арга, хэрэгслийн тав ба түүнээс дээш сонголттой, гурваас доошгүй сарын нөөцтэй болсон байна.

Зорилт 3. Бага насны хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд нотолгоонд тулгуурласан үр дүнтэй үйл ажиллагааг нэвтрүүлэх, дэлхийн хөгжингүй улс орнуудад нэвтрүүлж буй шинэ арга технологийг нутагшуулах, хүүхдийн хоол тэжээл, хөгжлийг дэмжих, тусламж, үйлчилгээний байнгын бэлэн байдлыг хангах, төвлөрлийг сааруулж, хүртээмжийг нэмэгдүүлэн, чанарыг сайжруулж, хүүхдийн сэргийлж болох өвчлөл эндэгдлийг бууруулах.

Хүрэх үр дүн 3.

3.1. Бага насны хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, тэдний хооллолт, хөгжлийг дэмжих чиглэлээр олон улсын байгууллагын зөвлөмж болгож буй нотолгоонд тулгуурласан интервенцийг хэрэгжүүлэн, сургалтад эрүүл мэндийн анхан болон лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн 80-аас доошгүй хувийг хамруулсан байна.

3.2. Бага насны хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, бичил тэжээлийн хангалт 80-аас доошгүй хувьд хүрсэн байх бөгөөд засвар үйлчилгээний санхүүжилт жил бүрийн төсөвт тусгагдаг болсон байна.

3.4. Урьдчилан сэргийлэх үзлэгт 9, 18, 36 сартай хүүхдийн хамрагдалт 98-иас доошгүй хувьд хүргэсэн байна.

3.5. Нярайн цогц скринингийн хамралтыг 80-аас доошгүй хувьд хүргэсэн байна.

3.6. Товлолт дархлаажуулалтын хамрагдалтыг 99.0 хувьд хүргэсэн байна.

3.7. Уушгины хатгалгаа өвчний шалтгаант 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 6 хувь, осол гэмтлээс шалтгаалсан 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тоог 110 хүртэл бууруулсан байна.

Зорилт 4. Өсвөр үеийнхэнд ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тогтвортой үргэлжлүүлэн, чанар, хүртээмжийг сайжруулах, хүүхэд өсвөр үеийнхний хөгжлийг дэмжих.

Хүрэх үр дүн 4.

4.1. Өсвөр үеийнхэнд ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх таатай орчинг бүрдүүлсэн кабинетыг бүх аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудад байгуулан, үйл ажиллагааг тогтворжуулсан байна.

4.2. Өсвөр үеийн эмч, мэргэжилтэн нарыг бүх аймаг, дүүрэгт бэлтгэж, ажлын байранд сургаж дадлагажуулсан байна.

4.3. Өсвөр үеийн кабинетын тэргүүн туршлагыг бусдад түгээж, өсвөр үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлсэн байна.

4.4. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлж буй эмч, эх баригч, сувилагч, сургуулийн эмч нарын 60-аас доошгүй хувийг өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж үзүүлэх, нөхөн үржихүйн эрүүл мэнд, хүсээгүй жирэмслэлт, ДОХ/ХДХВ/БЗДХ, хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр зөвлөгөө өгөх ур чадварт сургаж бэлтгэсэн байна.

4.5. Өсвөр үеийн хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалт 60-аас доошгүй хувьд хүрсэн байна.

Зорилт 5. Эмэгтэйчүүд, хүүхэд, тусгай хэрэгцээтэй зорилтот бүлгийнхний өвөрмөц хэрэгцээнд нийцүүлэн нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай үзүүлж, амьдралын чанарыг сайжруулах.

Хүрэх үр дүн 5.

5.1. Зорилтот бүлгийнхэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээрх мэдээлэл, сурталчилгааг тэдний хэрэгцээнд нийцүүлэн хүргэх тогтолцоо бүрдсэн байна.

5.2. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдалт 60-аас доошгүй хувьд хүрсэн байна.

5.3. Цэвэршилт, үргүйдлийн оношилгоо, эмчилгээний зааврыг шинэчлэн батлуулж, эмч, мэргэжилтэн нарыг сургалтад хамруулан, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвд энэ чиглэлээрх тусламж, үйлчилгээг үзүүлж хэвшсэн байна.

5.4. Үр хөндөлтийн түвшин 1000 эмэгтэйд 13.3 хүртэл буурсан байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Зорилт 1-ийн хүрээнд

1.1. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр үндэсний хэмжээнд мөрдөгдөж буй хууль, стандарт, журам, заавар, тушаалыг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, хамтрагч талуудад таниулж, тархаах.

1.2. Эмчилгээ, оношилгоог шинээр нэвтрүүлж, нутагшуулах үйл ажиллагааг өргөжүүлэн үр дүнтэй интервенцийг хэрэгжүүлэх, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, холбогдох бодлогын баримт бичгийг боловсруулж, түгээх.

1.3. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн тогтолцоо, санхүүжилт олгох арга аргачлал, өртгийг дахин үнэлэх, эх, хүүхэд, эмэгтэйчүүдийн зонхилон тохиолдох өвчин, эмгэгийн оношилгоо, эмчилгээг өргөжүүлэх, шинэ арга аргачлалыг нэвтрүүлэх, хяналт тавих, сэргээн засах боломжийг бий болгох.

1.4. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт, засвар үйлчилгээг тасралтгүй хийх тогтолцоог бүрдүүлж, санхүүжилтийг шийдвэрлэх.

1.5. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн хангалтын тасралтгүй байдлыг ханган, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад үйлчлүүлэгч жирэмслэхээс хамгаалах орчин үеийн арга, хэрэгслийн сонголт хийх боломжийг олгож, 5-аас доошгүй нэр төрлийн, 3-аас доошгүй сарын нөөцийг бүрдүүлсэн байх.

1.6. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд оролцогч хамтрагч талууд, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, бусад салбарууд, иргэний нийгэм, аж ахуйн нэгж, хамт олон, гэр бүл, иргэний идэвх санаачилгыг өдөөж, оролцоо, хариуцлага, хяналтыг нэмэгдүүлэх.

Зорилт 2-ын хүрээнд

2.1. Эх, нярайд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тогтолцоог олон улсын жижигт нийцүүлэн хөгжүүлэх (*Жирэмсний болон төрсний дараах үеийн хяналт, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг эрүүл мэндийн анхан шатны бусад*

тусламж үйлчилгээтэй уялдуулах, амаржих газар, нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээг хөгжлийн чиг хандлага бодлоготой уялдуулан шинэчлэх).

2.2. Эх, нярайн тусламж, үйлчилгээнд мөрдөгдөж буй стандарт, журам, заавар, тушаал шийдвэрүүдэд үнэлгээ хийж, шинэчлэн боловсруулж, батлуулан, хэрэгжүүлэх.

2.3. Эх барихын яаралтай болон цогц тусламж, үйлчилгээ үзүүлдэг эмч, мэргэжилтэн нарыг чадавхжуулах.

2.4. Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг (*Имж асаргаа, ангир уураг амлуулах, хөхөөр хооллох, арьс арьсаар шүргэлцүүлэх, дулаан алдалтаас сэргийлэх*) тогтвортой өргөжүүлэх.

2.5. Төрөх насны эмэгтэйчүүд, жирэмсэн болон төрсөн эмэгтэйг эрт илрүүлэг үзлэгт хамруулан эрүүлжүүлэх, жирэмслэлтэд бэлтгэх үйл ажиллагааг тогтмолжуулах.

2.6. Халдварын сэргийлэлт, хяналтыг эрчимжүүлж, эх барихын үжлийн оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх зааврыг нотолгоонд тулгуурлан шинэчлэн боловсруулах.

2.7. Дутуу төрөлт, амьгүй төрөлтийн шалтгаанд нөлөөлөх хүчин зүйлийг судлан тогтоож, хариу арга хэмжээг эрчимжүүлэх.

2.8. Жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн дутагдлаас сэргийлэх арга хэмжээг нэвтрүүлэх.

2.9. Жирэмсэн эмэгтэй, хөхүүл эхчүүдэд нэн шаардлагатай эм, бэлдмэл, аминдэм, дэмийг эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлттэй олгох боломжийг бүрдүүлэх.

2.10. Эх, ураг, нярайн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах чиглэлээр тандалт, судалгааны тэргүүлэх чиглэлийг тогтоож, судлаачдыг бэлтгэх.

2.11. Нярайн амьдралын чанарыг дээшлүүлэхэд нэн шаардлагатай эмчилгээ, оношилгоог шинээр нэвтрүүлэн, хөгжүүлэх (*тархи хөргөх, сурфактант эмчилгээ, пульсоксиметрийн илрүүлэг гэх мэт*).

2.12. Гамшиг онцгой байдал (зуд, үер, халдварт өвчин), нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн тохиолдолд эх, нярайд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад чиглэсэн бүх төрлийн нөөцийг бүрдүүлэх, төлөвлөх, хариу арга хэмжээний төлөвлөлт хийх, хэрэгжилтийг хангах ажил зохион байгуулах.

2.13. Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэлийн тохиолдлыг бүртгэж, мэдээлэхэд ДЭМБ-ын “Тооны цаана санаачилга” арга аргачлалыг өргөжүүлэх, шүүх шинжилгээний бүртгэл мэдээллийг эрүүл мэндийн статистик бүртгэлд бүрэн нэгтгэх.

2.14. Эсэн мэнд амаржихуйн мэдээлэл, сурталчилгааг нийтийн зах зээлд гаргаж, энэ чиглэлээрх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэн, аюултай шинжийг эрт таних, тусламж хайх боломжийг нэмэгдүүлэх.

Зорилт 3-ын хүрээнд

3.1. Бага насны хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, хоол тэжээл, хөгжлийг дэмжих чиглэлээр мөрдөгдөж буй бодлогын баримт бичиг, стандарт, журам, заавруудыг эргэн нягталж, олон улсын бусад байгууллагын зөвлөмж, хөгжингүй орны үр дүнтэй туршлагад үндэслэн шинэчлэн боловсруулж, батлуулан, таниулж, хэрэгжүүлэх.

3.2. Олон нийтэд түшиглэсэн хүүхдийн өвчний цогц менежментийн хэрэгжилтийг өргөжүүлж, эрчимжүүлэх.

3.3. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих ДЭМБ-ын үндсэн арга, аргачлалыг эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээтэй уялдуулан, хөгжүүлж, нутагшуулах.

3.4. Нялх, бага насны хүүхдийн хооллолтыг (эхийн сүүгээр хооллолт, нэмэгдэл хооллолт) дэмжих.

3.5. Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн сайжруулах, “Эрүүл шүд” аяныг төр болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, бусад салбарын оролцоотойгоор хэрэгжүүлэх.

3.6. Хүүхдэд үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламжийг хөгжүүлэх, энэ чиглэлээр мөрдөж буй журам зааврыг шинэчлэн боловсруулж, өрх, сум, түргэн тусламж, эмнэлгийн яаралтай тусламжийн хэсэгт ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг нэн тэргүүнд сургаж, дадлагажуулах.

3.7. Хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ болон хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлд нэн шаардлагатай хүний нөөцийг (*хэл засалч, хөдөлгөөн засалт, нярайн эмч, сувилагч, хүүхдийн мэс засалч, хоол зүйч гэх мэт*) орон нутгийн захиалга, хүүхдийн өвчин эмгэг хөдлөл зүйд тулгуурлан гадаад, дотоодын сургалтад хамруулан бэлтгэж, ажиллуулах.

3.8. Бага насны хүүхэд хамгааллыг сайжруулах, эцэг, эх, асран хамгаалагчдын мэдлэгийг дээшлүүлж, ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг засаг захиргааны анхан шатны нэгж, боловсрол, хэвлэл мэдээллийн байгууллага, албан тушаалтнуудтай хамтран хэрэгжүүлэх.

3.9. Хүүхдийн хавдрыг эрт илрүүлэх, эмчилгээ, оношилгоо эрт үеийн сэргээн засах тусламж, үйлчилгээний чиглэлээрх чадавхыг (*хүний нөөцийг бэлтгэх, эм эмнэлгийн хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх*) сайжруулах.

3.10. Сэргийлэх боломжтой өвчин эмгэгээс шалтгаалсан нас баралтыг бууруулахын тулд хүүхдийн осол гэмтэл, уушгины хатгалгаа, нярайн үжил халдвараас сэргийлэх чиглэлээрх арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлэх, товлот дархлаажуулалтын бүрэн хамралтыг нэмэгдүүлэх.

3.11. Хүүхдийн анагаахын чиглэлээр тусламж, үйлчилгээ үзүүлж буй эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж бэлтгэх.

3.12. Хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай эмнэлгийн тоног, төхөөрөмжийн шинэчлэлийг байнга хийж, шинэ технологи нэвтрүүлэхийн тулд эмч, эмнэлгийн мэргэжилтэн, инженер техникийн ажилтнуудыг тогтмол сургалтад хамруулан, чадавхжуулах ажлыг тасралтгүй зохион байгуулах.

3.13. Хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийг хүүхдийн өвчний цогц менежмент, нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, хүүхдийн хөгжлийг дэмжих, дархлаажуулалт, хүүхдийн хооллолт, хүүхдийн яаралтай тусламж зэрэг сэдвээр богино хугацааны ажлын байрны дадлагажуулах сургалтад хамруулж, тогтмолжуулах.

Зорилт 4-ийн хүрээнд

4.1. Өсвөр үеийнхэнд ээлтэй орчин бүрдүүлэх, өсвөр үеийн эмч, сэтгэлзүйчийг бэлтгэн, өсвөр үеийн кабинетуудыг тогтвортой ажиллуулах.

4.2. Сэтгэцийн эрүүл мэнд, дэлгэцийн зохистой хэрэглээ болон мансууруулах сэтгэц нөлөөт бодисын хэрэглээнээс татгалзах, донтолтоос сэргийлэх зорилгоор зөвлөгөө өгөх, эрт илрүүлэх, эмчлэх, хянах, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх

4.3. Хүүхдэд зонхилон тохиолдох харшлаас сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлж, эмчилгээ, оношилгооны чадавхыг сайжруулах.

4.4. Зүрх судасны эмгэг, стрептококкийн халдварыг илрүүлэн, оношилж, эмчлэн, эрүүлжүүлэх арга хэмжээг тасралтгүй зохион байгуулах.

4.5. Өсвөр үеийнхэнд тулгамдсан асуудалд зөвлөгөө өгөх ур чадварт өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч, эх баригч, сувилагч, нийгмийн ажилтан, сургуулийн эмч нарыг бэлтгэх.

4.6. Эх, хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийн (*зам тээврийн осол гэмтлээс сэргийлэх, үе тэнгийн дээрэлхэлтийг арилгах, зөв зан үйлийг төлөвшүүлэх, аливаа хэлбэрийн донтолтоос сэргийлэх*) чиглэлээрх мэдээлэл, сурталчилгааг тэдний өвөрмөц хэрэгцээнд нийцүүлэн түгээх, аж ахуй нэгжийг татан оролцуулж нийтийн зах зээлд гаргах, зөвлөгөө өгөх ур чадварыг сайжруулах.

4.7. Сургуульд суурилсан эрт илрүүлгийн үйл ажиллагааг зохион байгуулж, сурагчийн эрүүл мэндийн дэвтрийг хөтөлж хэвшүүлэх.

Зорилт 5-ын хүрээнд

5.1. Эмэгтэйчүүдийн дотоод шүүрлийн эмгэг, цэвэршилт, үргүйдлийн оношилгоо, эмчилгээний зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулан, эмэгтэйчүүд, дотоод шүүрлийн эмгэг, цэвэршилт, үргүйдлийн чиглэлээрх тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.

5.2. Тусгай хэрэгцээ шаардлагатай зорилтот бүлгийнхний (*хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, цэвэршилтийн насны эмэгтэйчүүд*) эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэдний хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэх.

5.5. Эх, нярай, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний зөвлөгөөнийг жил бүр тодорхой сэдвийн хүрээнд зохион байгуулж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх.

5.5. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийг нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, ДОХ/ХДХВ/БЗДХ-ын чиглэлээр зөвлөгөө өгөх ур чадварт сургах.

5.6. Бодлого боловсруулагчдад гамшиг, онцгой байдлын үед нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний талаар ухуулга, сурталчилгаа нөлөөллийн ажлыг хийх.

5.7. Эрүүл мэндийн статистик мэдээлэлд гамшгийн үеийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний үзүүлэлтүүдийг тусгах.

АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

➤ 2025-2028 он

ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД МӨРДӨХ ЗАРЧИМ

- Эрүүл мэндийн салбарын манлайлал, оролцогч талуудын түншлэл;
- Бодлого, шийдвэр тогтвортой;
- Хүний эрхэд суурилсан, үйлчлүүлэгч төвтэй;
- Жендэрийн мэдрэмжтэй;
- Нотолгоонд тулгуурласан;
- Хариуцлагатай;
- Хүмүүнлэг.

ОРОЛЦОГЧ ТАЛУУД, ГОЛ ЧИГ ҮҮРЭГ

Байгууллагууд	Чиг үүрэг
Эрүүл мэндийн яам	- Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдан зохицуулах, - Салбар дундын оролцоог хангах, үйл ажиллагааг уялдуулах, - Тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн эрхзүйн орчинг болон нийгмийн баталгааг хангах, - Олон улсын байгууллагын дэмжлэг үйл ажиллагааг зохицуулах, - Хэрэгжилтийг хянах, дэмжлэгт хяналт хийх.
Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	- Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтийг зохицуулах, хяналт тавих.
Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	- Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах, тасралтгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, зохицуулах, - Нөөц бүрдүүлэлтэд дэмжлэг үзүүлэх, зохицуулах, - Эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх.
Анхан болон Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагууд	- Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд мөрдөгдөж буй заавар стандартын төслийг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах, - Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийг сургаж дадлагажуулах, - Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шинээр нэвтрүүлэх арга, аргачлалыг турших, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг удирдан хийх, - Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээг цаг алдалгүй үзүүлж, зайн оношилгоо, эмчилгээг хийх, орон нутгийн эмч мэргэжилтнүүдэд зөвлөгөө өгөх, - Эх, хүүхэд, эмэгтэйчүүдийн өвчин, эндэгдэлд тандалт хийж, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх.
Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар	- Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөөний орон нутгийн түвшинд хэрэгжилтийг удирдан зохицуулах, - Орон нутгийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоог хангах, үйл ажиллагааг уялдуулах, - Тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн эрхзүйн орчинг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах, - Нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, - Олон улсын байгууллагын дэмжлэг үйл ажиллагааг зохицуулах, - Иргэдэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг удирдан зохицуулах,

	- Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, дэмжлэгт хяналт хийх.
Төрийн болон хувийн өмчит эрүүл мэндийн байгууллагууд	- Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн арга хэмжээний төлөвлөгөөний холбогдох үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх.
Олон улсын байгууллагууд	- Олон улсын байгууллагуудаас өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлэх, нотолгоонд тулгуурласан арга хэмжээг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, - Бодлогын баримт бичиг, журам, заавар, стандарт боловсруулахад дэмжлэг үзүүлэх - Сургалтын хөтөлбөр боловсруулах, сургагч багшийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, - Нотолгоонд тулгуурласан арга аргачлал, интервенцийг таниулах, нэвтрүүлэх, нутагшуулахад дэмжлэг үзүүлж, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургах, гарын авлага, сургалтын материалаар хангахад дэмжлэг үзүүлэх, - Нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, гамшиг онцгой байдал, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсэхээс сэргийлэх хариу арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэх, нөөц бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, - Дэмжлэгт хяналт хийхэд дэмжлэг үзүүлэх, - Нэн шаардлагатай судалгаа, үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлэх, - Иргэдэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил хийхэд дэмжлэг үзүүлэх.
Анагаах ухааны боловсрол олгох төрийн болон хувийн өмчит их, дээд сургууль, коллеж	- Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж, дадлагажуулах, - Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээрх сургалтын хөтөлбөрүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд шинэчлэх, - Дэмжлэгт хяналт хийхэд оролцох, - Нэн шаардлагатай судалгаа, үнэлгээ хийх.
Мэргэжлийн нийгэмлэг, холбоод	- Бодлогын баримт бичиг, журам, заавар, стандарт боловсруулахад дэмжлэг үзүүлж, оролцох, - Нотолгоонд тулгуурласан арга аргачлал, интервенцийг таниулах, нэвтрүүлэх, нутагшуулахад дэмжлэг үзүүлж, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургах, гарын авлага, сургалтын материалаар хангахад дэмжлэг үзүүлэх, - Дэмжлэгт хяналт хийхэд оролцох, - Нэн шаардлагатай үнэлгээ, судалгаа хийхэд дэмжлэг үзүүлэх, - Иргэдэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил хийхэд дэмжлэг үзүүлэх, - Эмч, эмнэлгийн мэргэжилтний эрхийг хамгаалахад манлайлах.

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГТГЭЛ

Нийт 5 зорилтын хүрээнд 81 үйл ажиллагааг төлөвлөсөн. Үүнд:

1. Зорилт 1-ийг хэрэгжүүлэх 10 үйл ажиллагаа
2. Зорилт 2-ыг хэрэгжүүлэх 30 үйл ажиллагаа
3. Зорилт 3-ыг хэрэгжүүлэх 17 үйл ажиллагаа
4. Зорилт 4-ийн хэрэгжүүлэх 12 үйл ажиллагаа
5. Зорилт 5-ыг хэрэгжүүлэх 12 үйл ажиллагаа

Чиглэл	Төлөвлөсөн үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа				Мэдээллийн эх сурвалж
		2025 он	2026 он	2027 он	2028 он	
Бодлогын баримт, бичиг (стандарт, заавар, журам)	1 хууль, 2 стандарт, 4 тогтоол, 26 тушаал					Батлагдсан хууль, стандарт, заавар, журмын эх хуулбар
Хүний нөөцийг чадавхжуулах сургалт, зөвлөгөөн	22					Эрүүл мэндийн сайдын тушаал, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн тайлан, Эрүүл мэндийн байгууллагын тайлан
Хөрөнгө оруулалт	7					Эрүүл мэндийн сайдын тушаал, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилт, Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилт, Орон нутгийн санхүүжилт, Аудитын дүгнэлт, Санхүүгийн тайлан
Тусламж, үйлчилгээ	17					Эрүүл мэндийн даатгалын сан, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв

					Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллага
Мэдээлэл, сурталчилгаа, сургалт	12				Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилт, Орон нутгийн санхүүжилт, Олон улсын байгууллагын санхүүжилтийн тайлан
Инновац, тусламж, үйлчилгээнд шинээр нэвтрүүлэх арга аргачлал	Шинээр нэвтрүүлсэн арга, аргачлал, технологийн тоо				Батлагдсан заавар, арга аргачлал, Сургагдсан хүний нөөц, Тухайн тусламж, үйлчилгээ үзүүлсэн үйлчлүүлэгчийн тоо, Хувийн хэвшлийн байгууллагын оролцоо
